



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 9/449

Мандалговь

Дундговь аймгийн үүсэл хөгжлийн тухай
түүхийн ном бүтээх ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5(а), Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.13, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний 3.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн үүсэл хөгжлийн тухай түүхийн ном бүтээх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир(Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Гишүүд: А.Нарантуяа (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
М.Болор-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)
Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл урлагийн газрын дарга)
Л.Оюунбаяр (Боловсрол, соёл урлагийн газрын албаны дарга)
З.Цэвээнравдан (Монгол Улсын Гавьяат багш)
Н.Тогтох ("Элгэмсэг дотно Дундговь холбоо" ТББ-ын тэргүүн)
Л.Цэвээнравдан("Элгэмсэг дотно Дундговь холбоо" ТББ-ын дэд тэргүүн)
И.Бямбарагчаа ("Элгэмсэг дотно Дундговь холбоо" ТББ-ын дэд тэргүүн)
Б.Балжинням (Түүхч, түүхийн ухааны доктор, профессор)
Нарийн бичгийн дарга: Ц.Одончимэг (Төв Номын сангийн захирал)

Хоёр. Аймгийн түүхэн үүсэл хөгжлийн талаар судалгаа хийж, номонд оруулах материал бүрдүүлэх, номын эх бэлтгэлийг хийлгэж, хэвлүүлэх ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхийг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190411